



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/506

Мандалговь

Г "Эрүүл иргэнтэй Дундговь" аймгийн дэд
хөтөлбөр батлах тухай Г

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 10.1.4, 11.2.3 дахь заалтууд, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.1.10 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Эрүүл иргэнтэй Дундговь" аймгийн дэд хөтөлбөрийг баталсугай.

Хоёр. "Эрүүл иргэнтэй Дундговь" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Гурав. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (А.Нарантуяа), Эрүүл мэндийн газрын дарга (Г.Бат-Орших)-д тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг олон улсын байгууллагын төсөл хөтөлбөр, хандив тусламж болон аймаг, сумын орон нутгийн төсөвт тусган ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат), Эрүүл мэндийн газрын дарга (Г.Бат-Орших), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Г.Самданцоодол)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010560